


“Фридрих-Эбертийн сангийн
Дотоодын тэтгэлэгт хөтөлбөрийн судалгааны ажил”



МОНГОЛ УЛС ДАХЬ КРИПТОВАЛЮТЫН ОРЧНЫ СУДАЛГАА

МОНГОЛ УЛС ДАХЬ КРИПТОВАЛЮТЫН ОРЧНЫ СУДАЛГАА

Зөвлөх: Ж.Мэндээ

Бэлтгэсэн: Б.Улсболд, Ч.Авидмаа, Б.Батхүү, Г.Наранцэцэг, Э.Тамир



Улаанбаатар 2021

	Агуулга	
Өмнөх үг		5
I. Удиртгал		6
ii. Судалгааны ажлын хамрах хүрээ		6
iii. Судалгааны арга зүй		7
II. Криптовалютын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа		7
i. Криптовалютын эрх зүйн статус		7
ii. Ерөнхий зохицуулалт хийж буй асуудлууд		8
iii. Монгол Улс дахь криптовалютын өнөөгийн байдал		10
III. Олон нийтийн криптовалютын талаарх ойлголтыг тодруулах судалгаа		11
i. Судалгааны зорилго, үндэслэл		11
ii. Судалгааны үр дүн		11
IV. Дүгнэлт		18
Ашигласан материал		19
Тэмдэглэл		20

Өмнөх үг

Сүүлийн жилүүдэд криптовалютаар хийгдэж буй арилжаа эрс нэмэгдсэн . Үүний зэрэгцээ, криптовалютын хэрэглээ уламжлалт мөнгөн тэмдэгтээс ялгаатай бөгөөд цөөн тооны бүлэг хүмүүс л тус валютын тухай мэдлэгтэй байдаг тул гарт баригдаж нүдэнд харагддаггүй, тодорхойлоход хэцүү шинэ үзэгдэл хэвээр байна.

Ялангуяа мөнгөн тэмдэгтүүдийн эргэлт итгэлцэл дээр тулгуурладаг. Хэрэв криптовалют дэлхий нийтийн мөнгө хүүлэлтийн объект болчихвол юу болох вэ? Хялбар аргаар баяжсан тухай сайн жишээ, криптовалютад хөрөнгө оруулж, байдгаа барсан хүмүүсийн тухай мэдээ мэдээллийг даван гарч чадах уу?

Эрх зүйн зохицуулалтгүй криптовалютын салбар нь ихэвчлэн залуу хүмүүсийн сонирхлыг соронздон татаж байна. Гэсэн хэдий ч улс орнууд олны анхаарал татсан энэ шинэ үзэгдлийг үндэсний хууль тогтоомждоо тусгаж хуулийн аргамжаанд оруулж чадаагүй байна. Иймд энэхүү шинэ үзэгдлийг нэн ялангуяа залуу хүмүүст ойлгомжтой болгох хэрэгцээ шаардлага үүсэж байгаа бөгөөд тэдний криптовалютын талаар юу бодож, юу мэддэгийг асуух нь хамгаас чухал юм.

Ийм ч учраас Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт олон залуусын дундаас шалгарч сонгогдсон таван залуустаа энэхүү сонирхолтой сэдвийг сонгон авч судалсанд би маш их баяртай байна.

Ч.Авидмаа, Б.Батхүү, Г.Наранцэцэг, Э.Тамир, Б.Улсболд нар маань Монголын залуучууд криптовалютын талаар юу мэддэг вэ? гэсэн асуултын хүрээнд судалгаа хийж, судалгааныхаа дүн дээр суурилан криптовалютын талаар Монгол Улсад баримтлах бодлогын зөвлөмж боловсруулахыг оролдлого хийсэн юм.

Тэтгэлэгт оюутнууд маань энэ сэдвээр хийсэн судалгаагаа үргэлжлүүлнэ гэдэгт бид найдаж байна. Миний бие Фридрих-Эбертийн сангийн тэтгэлэгт оюутнуудын судалгааны ажлын үр дүнтэй танилцах явцдаа криптовалютын талаар зохих мэдлэг олж авсандаа олзуурхахын цацуу уншигч та бүхэндээ мөн уншихыг зөвлөж байна.

I. Удиртгал

i. Оршил

Соёл иргэншлийн гол тулгуур болох арилжаа худалдаанд хувьсгал хийсэн гол нээлтүүдийн нэг нь мөнгө билээ. Мөнгө нь төрөөс баталгаажуулсан, хязгаарлагдмал нөөцтэй, дурын этгээд хуурамчаар үйлдэх боломжгүй ба эрх бүхий этгээдийн хөтөлж буй мөнгөний бүртгэл үнэн зөв гэсэн хүмүүсийн итгэлд үндэслэн үнэ цэнэтэй байсаар иржээ.

Мөнгөний үнэ цэнэд итгэх итгэлийг баталгаажуулахын тулд төрөөс эхлээд алтан стандартыг мөрдөж дараа нь төв банкнаас баталгаа гаргаж байв. Баталгаа гаргахдаа нийтээр хүлээн зөвшөөрсөн нэгдсэн данс бүртгэл хөтөлгөч буюу төрийн оролцоо байхгүй байсан юм. Энэ нь мөнгөний 5,000 орчим жилийн хөгжлийн түүхэнд олон нийтийн итгэлийг баталгаажуулж, тухайн мөнгийг үнэ цэнэтэй байлгах аргыг сэдэж олж чадаагүй байсныг илтгэж байна.

Харин 2008 онд анх блокчэйн технологийг ашиглаж биткойныг гаргаж ирснээр зах зээлд оролцогч бүр аливаа гүйлгээний хувьд бие даасан хяналтыг хэрэгжүүлэх боломжтой болж криптовалютын ойлголт гарч ирсэн байдаг. Энэ нь нийтийн итгэлийг хүлээсэн, үнэ цэнэ бүхий, төвлөрсөн бүртгэлд суурилагагүй валют юм. Энд дурдагдсан блокчэйн технологийг энгийнээр тайлбарлавал “тухайн өгөгдөл буюу датад орсон өөрчлөлт нэг бүрийг тэмдэглэн авч хадгалдаг төвлөрсөн бус өгөгдлийн бааз” хэмээн ойлгож болно.¹ Өөрөөр хэлбэл, банк, кастодиан, үнэт цаасны брокер гэх мэт гуравдагч этгээд мөнгөний шилжилт хөдөлгөөнийг тэмдэглэн авч болдог. Тус системд хамааралтай бүх этгээд тухайн төвлөрсөн өгөгдлийн сангийн бүртгэгч буюу хянагч болсноор тухайн криптовалютын үнэ цэнийг тогтоодог байна. Гэхдээ тэд тус санд ямар нэгэн өөрчлөлт хийх боломжгүй байдаг.

Тэгвэл анх биткойн гарснаас хойш аль хэдийн дэлхий даяар танигдаж зарим тохиолдолд өдөр тутмын төлбөр тооцооны хэрэгсэл болон хэрэглээнд орсон байгаа нь криптовалютын хөгжил нэн хурдацтай байгааг илтгэж байна. Харин Монгол улсын хувьд криптовалютын судалгаа, мэдээлэл дутмагаас түүнтэй холбоотой нийгэм, эдийн засаг, эрх зүйн тулгамдсан асуудлууд үүсээд байгаа нь энэхүү судалгааг хийх болсон гол шалтгаан юм.

ii. Судалгааны ажлын хамрах хүрээ

Энэхүү судалгааны хүрээнд криптовалюттай холбоотой үндсэн 2 гол асуудлыг хөндөх болсон. Үүнд: 1) Криптовалютын талаар мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан үйлдэгдэж буй залилангийн шинжтэй үйл ажиллагаанаас сэрэмжлэхийг нийтэд анхааруулах 2) Криптовалютын талаар эрх зүйн зохицуулалтын дутмаг

1 АрдАкадеми, Блокчэйн-Интернетийн шинэ хувьсгал, 2021 ([Холбоос](#))

байдал ба түүний үр дагаврыг олон нийтэд танилцуулах зорилготой.

iii. Судалгааны арга зүй

Криптовалютын талаар олон нийт ямар мэдээлэлтэй байгаа талаар асуулга боловсруулан, иргэдээс асуулга авч, тэдний мэдээллийн баримжааг асуулгын үндсэн дээр цуглууллаа. Нийгэм дэх залилангийн шинжтэй үйл ажиллагааны талаар асуулгад дүн шинжилгээ хийх, баримт мэдээ цуглуулах, нарийвчлан судлах болон ажиглалтын арга зүйг ашигласан болно. Харин криптовалютын эрх зүйн орчны судалгааг хийхдээ баримт бичгийн, агуулгын болон харьцуулсан шинжилгээний аргыг ашигласан.

II. Криптовалютын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Дэлхий даяар криптовалютын хэрэглээ нэмэгдсэнээр олон тооны улсууд тэдгээрт тохирох эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг 2014 оноос хойш хэрэгжүүлж эхэлсэн байна. Гэхдээ улс орнууд криптовалютын талаар өөр хоорондоо ялгаатай буюу зарим тохиолдолд эрс тэс ялгаатай байдлаар зохицуулалт хийж байгааг онцлох нь зүйтэй юм. Тодруулбал, БНХАУ, Пакистан гэх мэт улсуудад криптовалюттай холбогдох бүх асуудлыг буюу арилжаалах, олборлох, төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглах зэргийг хориглосон байхад Япон улсад криптовалютыг төлбөр тооцооны хэрэгслээр хүлээн зөвшөөрөөд зогсохгүй криптовалюттай холбоотой бизнес эрхлэгчдийн холбоо байгуулагдаж, тухайн төрлийн бизнесийн үйл ажиллагаанд тавигдах норм, стандартуудыг боловсруулж, мөрдүүлж байна. Ерөнхийдөө криптовалютыг хамгийн өргөн хүрээнд зохицуулсан улсуудад Япон, Канад, Европын Холбооны гишүүн улсууд, АНУ, БНХАУ, Аргентин, Австрали, Өмнөд Африк хамаарна.

Тэгвэл дараах хэсгүүдэд криптовалютын эрх зүйн статус, түүнтэй холбогдох эрх зүйн зохицуулалт хийх боломжтой асуудлыг харьцуулан судалж, Монгол улс дахь криптовалютын өнөөгийн байдлын талаар дэлгэрүүлэн авч үзье.

i. Криптовалютын эрх зүйн статус

Криптовалютын гол мөн чанар нь төрийн байгууллага эсвэл төв банкнаас хараат бус буюу нэгдсэн байдлаар зохицуулагддаггүй, төв банкны баталгааг агуулдаггүй байх явдал юм. Иймд одоогоор криптовалютыг хууль ёсны фиатвалют гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдол алга байна. Энэ нь түүний гол мөн чанар болох төрийн байгууллага эсвэл төв банкнаас хараат бус буюу нэгдсэн байдлаар зохицуулагдаагүй, төв банкны баталгааг агуулаагүй зэрэг шинжүүдтэй холбоотой.

Иймд, зарим улсууд криптовалютыг ихэвчлэн үнэ цэнэ бүхий “бараа” гэж үзэх хандлагатай байдаг.² Ингэснээр аливаа криптовалютаар төлж хийсэн хэлцэл нь

² АНУ-ын Конгрессын Номын Сан, Дэлхий даяарх криптовалютын эрх зүйн зохицуулалтын судалгаа, 2018 (Холбоос)

бартерын хэлцэлтэй адил гэж тооцогдох ба хэн нэгэн өөрийн фиат валют буюу мөнгөөрөө криптовалют худалдаж авах тохиолдолд ямар нэгэн бараа худалдаж авахтай адилаар НӨАТ төлөх асуудал гарч буй юм.

Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд 2015 онд Европын Шүүхээс криптовалютыг төлбөр тооцооны хэрэгсэл гэдэг талаас нь тайлбарласан ба криптовалют худалдаж авах нь жишээлбэл, монгол төгрөгөөр АНУ-ын доллар худалдан авч байгаа нөхцөл байдалтай адил гэх үндэслэлээр НӨАТ-аас чөлөөлөгдөх ёстой гэж үзжээ.³ Үүнтэй холбогдуулан Европын Холбооны орнууд криптовалютыг бараа гэж үзэн НӨАТ ногдуулахын оронд төлбөр тооцооны хэрэгсэл буюу валют гэдэг өнцгөөс авч үзэж, тохирох эрх зүйн зохицуулалтуудыг хийж эхэлсэн. Товч дүгнэвэл, дэлхий нийтэд криптовалютын эрх зүйн статусыг нэг бол тодорхой үнэ цэнэ бүхий бараа эсвэл төлбөр тооцооны хэрэгсэл гэж тодорхойлох хоёр гол хандлага оршиж байна.

ii. Ерөнхий зохицуулалт хийж буй асуудлууд

Криптовалюттай холбогдох яг ямар асуудлуудыг эрх зүйн хүрээнд зохицуулах талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн практик тогтоогүй байгаа хэдий ч криптовалютын мөн чанартай холбогдуулан дараах асуудлуудын хүрээнд эрх зүйн зохицуулалт хийх боломжтой юм.

1. Татвар

Өмнө дурдсанчлан криптовалютыг бараа буюу төлбөр тооцооны хэрэгсэл болох гэдгээс шалтгаалаад криптовалютын арилжаанд НӨАТ ногдуулах асуудал хөндөгддөг ба энэ чиглэлээр ихэнх улс орнууд криптовалютыг төлбөр тооцооны хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрөөгүй хэдий ч түүний арилжаанд НӨАТ ногдуулахгүй байх хандлагыг баримталж байгаа юм.

Тэгвэл криптовалютын арилжаанаас олж болох ашгийн хувьд хэрхэн татвар ногдуулж байна вэ гэвэл тус ашгийг хөрөнгийн орлогод тооцон хувь хүний эсвэл аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах нь түгээмэл байна. Үүнийг компанийн хувьцааны арилжаа хийж ашиг олсонтой холбогдуулан татвар ногдуулдаг зарчимтай зүйрлэж болох юм. Арилжааны орлогын татварын бодит жишээний гэвэл хамгийн сүүлд БНСУ-д 2022 оны татварын жилээс эхлээд криптовалютын арилжаанаас олсон орлогын дүнд 20 хувийн татвар ногдуулах тухай шийдвэр гарсан.⁴

Криптовалюттай холбоотой нэг онцгой ойлголтын хувьд криптовалют олборлох буюу блокчейны дараагийн кодыг зөв тааснаар тухайн криптовалютын системээс урамшуулал болгож тодорхой тооны криптовалютыг авах явдал юм. Энэ нь үндсэндээ хөрөнгийг шинээр бий болгож байгаа ойлголт бөгөөд криптовалют

3 Хэргийн дугаар C-264/14, Skatteverket v. David Hedqvist, ECLI:EU:C:2015:718 (Холбоос)

4 Бизнес Инсайдер, Өмнөд Солонгос Криптовалютод 20 хувийн татвар ногдуулна нийтлэл, 2021 (Холбоос)

олборлох ажил гүйцэтгэснээрээ үнэ цэнэ буюу хөрөнгө бий болгож байгаа үйл явц ба үүнд онолын хувьд татвар ногдуулах боломжтой юм. Гэвч улс орнууд одоогоор олборлогчийг болон урамшуулалд авсан криптовалютын хэмжээг тогтоож, хянах боломжгүй гэх үндэслэлээр энэхүү асуудлын хүрээнд татвар ногдуулж эхлээгүй байна.

2. Арилжаа, түүнд оролцогч этгээдүүд

Криптовалютын үндсэн онцлог нь өмнө дурдсанчлан блокчэйн зарчмаар данс бүртгэлийг криптовалют олборлогчдын тусламжтайгаар тухайн криптовалютын бүх эзэмшигчид тус тусдаа нягталж, хөтлөх тухай ойлголт билээ. Ингэснээр ганцхан төрийн аливаа институцээс зохицуулах боломжийг хязгаарлаад зогсохгүй аливаа арилжаа хийхэд нэгдсэн бүртгэл хөтлөх шаардлагатай брокер, кастодиан болон хөрөнгийн бирж шаардлагагүй болох юм. Өөрөөр хэлбэл, хэн нэгэн өөрийн криптовалютыг хэнээс ч хамааралгүйгээр болон цаг хугацааны хязгаарлалтгүйгээр өөр нэгэн этгээдэд буюу дансанд шилжүүлэх боломжтой байх юм. Тэгэхээр үндсэндээ криптовалютын арилжаа хийгдэхэд брокер, бирж гэх мэтийн гуравдагч этгээд зайлшгүй шаардлагатай биш болж байна.

Гэхдээ криптовалютаа хөндлөнгийн худалдан авагчид шилжүүлээд түүнтэй холбогдох төлбөрөө авах баталгаа худалдагчид хэрэгтэй буюу арилжаа хийхийн тулд нөгөө талтайгаа биечлэн харилцах шаардлага гарч ирэх учраас эдгээр асуудлыг шийдэж, арилжааг хялбарчлах үүднээс гуравдагч этгээдийн оролцоо бүхий арилжаалах талбар хэрэгтэй болдог. Тухайн арилжааны талбар нь зайлшгүй хийх нэгдсэн бүртгэлийг хариуцахгүй, энгийнээр бол авах, зарах захиалгыг хооронд нь тохируулж, төлбөр төлөлтийг баталгаажуулах үүргийг л гүйцэтгэж, тухайн үйлчилгээнийхээ хариу болгож шимтгэл авдаг байна. Биржтэй төстэй үйл ажиллагаа явуулж буй энэхүү этгээд нь аливаа бүртгэл хөтлөх болон зохицуулалт бүхий үнэт цаасыг арилжаалдаггүй тул ихэнх тохиолдолд ямар нэгэн тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд үнэт цаасны зах зээлийн хуульд заасан зохицуулалттай этгээдэд хамаарадаггүй юм.

Биржийн ажил үүргийг гүйцэтгэгч байгаатай адилаар криптовалютын арилжааг илүү найдвартай болгоход туслах зориулалтаар кастодианы үйл ажиллагаа эрхлэгчид мөн гарч ирсэн. Тухайн байгууллагууд нь криптовалютын эзэмшлийг нотлох кодуудыг хадгалж, ашиглах замаар “крипто түрийвч”-ийн үүргийг гүйцэтгэдэг ба үйлчилгээ үзүүлсэнтэйгээ холбоотойгоор шимтгэл авдаг байна. Ихэнх орнуудад криптовалютын кастодианы үйл ажиллагаа эрхлэгч нь мөн л хуулийн зохицуулалттай этгээдэд хамаарахгүй юм.

3. Криптовалют олборлох асуудлаар

Криптовалют олборлох гэдэг нь үндсэндээ системийн арилжааны бүртгэлийг хөтлөхөд шаардагдах блок бүрд хамаарах олон орон бүхий (ихэвчлэн 256) кодыг компьютероор таалгаж, зөв таасан тохиолдолд бүртгэлийг баталгаажуулан

системээс кодыг олсон этгээдэд урамшууллын криптовалют олгох процесс юм. Ихэвчлэн маш өндөр хүчин чадал бүхий (тодорхой хугацаанд аль болох олон код тааж, ачааллуулж чадах) компьютерыг удаан хугацаагаар ажиллуулах нь маш их хэмжээний эрчим хүч зарцуулдаг бөгөөд улс орнууд тухайн эрчим хүч зарцуулалттай холбоотойгоор шимтгэл ногдуулах эсвэл хязгаарлалт тавих гэх мэт зохицуулалтыг хийж болохуйц юм.

Дэлхийд цаг уурын өөрчлөлтийн явц хурдсаж байгаатай холбоотойгоор ийнхүү зарим хүмүүсийн нүдэнд хий дэмий гэж харагдаж болох зүйлд маш их хэмжээний эрчим хүч зарцуулах нь зохистой эсэх асуудал мөн урган гарч ирдэг ба байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой үүргийг ч ногдуулах боломжтой гэж бид үзэж байна.

4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх асуудлаар

Нэгдсэн санхүүгийн бүртгэл хөтөлдөггүй ба түүнийг нь хянах банк, төрийн эрх бүхий байгууллагууд байхгүй учраас хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг криптовалютын хэлбэрээр нуух, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор хэрэглэх эрсдэлтэй юм.

Иймд энэ асуудлын хүрээнд банк, үнэт цаасны зохицуулах байгууллагууд өөрсдөө шууд криптовалютын арилжаанд хяналт тавьж оролцох боломжгүй учир улс орнуудад харин арилжаанд оролцогч криптовалютын бирж, кастодиан болон төлбөрийн даалгаврыг гүйцэтгэн оролцож буй банк болон бусад санхүүгийн байгууллагуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэхээр авч хэрэгжүүлдэг комплайнс хийх үүрэг оногдуулах замаар эрх зүйн зохицуулалт хийх боломжтой юм.

iii. Монгол Улс дахь криптовалютын өнөөгийн байдал

Монгол Улсын хувьд Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2017 оны 10 дугаар сард криптовалютын зохицуулалтын талаар мэдэгдэл гаргасан. Түүнийг өнөөг хүртэл баримталж байгаа.⁵ Тус мэдэгдэлд үндсэндээ Монгол улсад криптовалютын талаар аливаа эрх зүйн зохицуулалтын орчин бүрэлдээгүй байгаа ба тухайн харилцаанд оролцсон этгээдүүд ашиг, эрсдэлээ өөрсдөө хариуцна хэмээсэн. Тухайлбал,

“Хэрэв Та өөрийн итгэл үнэмшлээр төрийн зохицуулалтгүй, зөвшөөрөгдөөгүй санхүүгийн аливаа үйл ажиллагаанд хөрөнгө, мөнгөө оруулбал энэ нь Иргэний хуулиар зохицуулагдах харилцаа тул ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, хохирлыг өөрөө бүрэн хариуцахыг Санхүүгийн зохицуулах хороо албан ёсоор мэдэгдэж байна” гэжээ.

5 СЗХ, Криптовалютын талаарх Санхүүгийн Зохицуулах Хорооны байр суурь, 2017 (Холбоос)

Иймд, төрийн зүгээс аливаа эрсдэлийн хамгаалалт олгохооргүй байгаа ч криптовалюттай холбоотой олсон аливаа ашиг, орлогын хувьд татвар төлөгчөөрөө тайлагнахгүй л бол татвар ногдуулах боломжгүй байх нөхцөл байдалтай байгаа юм.

III. Олон нийтийн криптовалютын талаарх ойлголтыг тодруулах судалгаа

i. Судалгааны зорилго, үндэслэл

Монгол Улсын криптовалютын зах зээл биткойны ханшийн өсөлтийн эхний үе болох 2017 оны сүүлээс эрчимтэй хөгжиж эхэлсэн ба криптовалютын зах зээлийн арилжаанд оролцдог, дотоодын биржүүдэд албан ёсны бүртгэлтэй нийт 150 гаруй мянган иргэд, аж ахуйн нэгж байдаг гэсэн тоог Монгол банкны 2021 оны "Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа"-нд дурдсан байна.⁶ Үүнээс үзэхэд Монгол улсын нийт хүн амын ойролцоогоор 4 хувь нь л криптовалютын арилжаанд оролцдог байна. Харин нийт хүн амын дунд криптовалютын талаар мэдлэг мэдээлэл ямар түвшинд байгаа, мөн тодорхой мэдээлэлгүйгээс шалтгаалж хууран мэхлэлт, залиланд өртөж буй эсэх талаар тодорхой судалгаа хийгдээгүй нь энэ асуудлыг судлах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Энэхүү тоон түүвэр судалгаагаар Монгол улсын хүн амын тодорхой насны бүлгийн буюу залуучуудын шинэ үеийн дижитал төлбөрийн хэрэгсэл болох криптовалютын талаарх ойлголт, хандлагыг судлах зорилготой юм. Ийнхүү судлахдаа криптовалютыг уламжлалт мөнгөний адил үнэ цэнэтэй гэж үзэж буй эсэх, ямар зорилгоор ашигладаг зэргээс залуусын криптовалютын талаарх хандлагыг илрүүлэх юм.

Монгол улсын залуучуудын криптовалютын талаарх ойлголт, хандлагыг тодруулах зорилгоор 18-34 насны нийт 235 иргэнийг судалгаанд хамруулсан. Ковид-19 цар тахлын хөл хорионоос шалтгаалж судалгааны тоон мэдээллийг онлайн орчинд буюу Google Forms софтверийн тусламжтайгаар цуглуулсан бол судалгааны мэдээллийг SPSS23 программ ашиглан боловсруулсан болно.

ii. Судалгааны үр дүн

Судалгаанд 18-34 насны нийт 235 иргэн оролцсоноос 188(80%) нь буюу дийлэнх нь 18-24 нас, харин үлдсэн 47 (20%) нь бол 25-34 насны залуус байгааг График1-т үзүүлсэн болно.

6 Монгол банк, 2021. Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа

График 1. Судалгаанд оролцогчид насны бүлгээр




График1-ээс харахад нийт оролцогчид хүйсийн хувьд 82(34.9%) нь эрэгтэй, 153(65.1%) нь эмэгтэй байна.

Оролцогчдоос криптовалютын талаар сонсож байсан эсэхийг тодруулахад нийт оролцогчдын 164 (65.3%) нь сонсож байсан, харин үлдсэн 86 (34.7%) нь сонсож байгаагүй хэмээн хариулсан. Криптовалютын талаар сонсож байсан эсэх, хүйс болон боловсролын байдлыг график 2 –т үзүүлсэн болно.

График 2. Криптовалютын талаар сонсож байсан эсэх, хүйс болон боловсролын байдал




График2-т үзүүлсэн судалгааны үр дүнгээс харахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү криптовалютын талаар сонсож байсан гэж хариулсан байна. Мөн судалгаанд оролцогчдын криптовалютын талаар сонсож байсан эсэх нь боловсролын байдлаас төдийлөн хамааралгүй байгаа нь (1) хамаарал тооцсон үнэлгээнээс харагдаж байна.

$$\chi^2(1, N = 235) = 20.338, p = .000. (1)$$

Криптовалютын талаар сонсож байгаагүй оролцогчдыг судалгаанаас шууд хасч, криптовалютын талаар сонсож байсан хүмүүс үргэлжлүүлэн судалгаанд оролцсон болно. Судалгаанд оролцогчдыг Криптовалютыг анх сонсож байсан эх сурвалжаар нь харьцуулан График 3-т үзүүллээ.

График 3. Криптовалютыг анх сонсож байсан эх сурвалж




График 3-аас харахад Оролцогчдын ихэнх нь буюу 97 (62.2%) нь олон нийтийн сүлжээ, 25 (16%) нь ойр дотныхноосоо криптовалютын талаар анх сонсож байсан бол хамгийн бага буюу 3(1.9%)нь ном болон бусад материалаас мэдэж байсан байна. Мөн судалгаанд оролцогчдын Блокчейн технологийн талаарх ойлголтыг График 4-өөс харж болно.

График 4. Блокчейн технологийн талаарх ойлголт




График 4-өөс авч үзэхэд судалгаанд оролцогчдын блокчейн технологийн талаарх ойлголтыг өөрсдөөр нь 1-5 оноогоор (1-юу ч мэдэхгүй, 5-маш сайн мэднэ) үнэлүүлэхэд оролцогчдын 18 (11.5%) нь сайн, 12 (5.1%) маш сайн мэднэ гэсэн хариултыг өгсөн байна. Мөн уг үнэлгээг Mann-Whitney U тестээр шинжлэхэд эрэгтэй ($M=2.8$), эмэгтэй ($M=2.4$) хүйсээс хамаарсан ялгаа ажиглагдахгүй байгаа нь (2) үнэлгээнээс харагдаж байна.

$$U=2486.5, p=.053.(2)$$

Түүнчлэн, оролцогчдоос криптовалютын үнэ цэнийг уламжлалт мөнгөтэй харьцуулахыг хүсэхэд 100 (64.9%) нь уламжлалт мөнгөнөөс адил болон илүү үнэ цэнэтэй гэсэн хариултыг өгсөн байгааг Хүснэгт 1-т үзүүлээ.

Хүснэгт 1. Блокчейн технологийн талаарх мэдлэг ба криптовалютын үнэ цэнэд өгсөн үнэлгээний харьцаа, хувиар

		Блокчейн технологийн талаарх мэдлэг					Нийт
		Юу ч мэдэхгүй	Бага зэрэг мэднэ	Дунд зэрэг мэднэ	Сайн мэднэ	Маш сайн мэднэ	
Криптовалют уламжлалт мөнгөнөөс үнэ цэнэтэй эсэх	Илүү үнэ цэнэтэй	28.6	24.4	40	61.1	66.7	38.3
	Адил үнэ цэнэтэй	10.7	36.6	27.3	33.3	16.6	26.6
	Бага үнэ цэнэтэй	17.9	24.4	20	5.6	16.7	18.8
	Мэдэхгүй	42.9	15.6	12.7	0	0	16.2
Нийт		100	100	100	100	100	100

Мөн *Kruskal Wallis H* тест ашиглан шинжилж үзэхэд хүмүүсийн блокчейн технологийн мэдлэг дээшлэх тусам криптовалютыг үнэ цэнэтэйд тооцдог болох нь (3) үнэлгээнээс харагдаж байна.

$$H(3)=20.756, p=.000(\text{Хүснэгт1}).(3)$$

Мөн оролцогчдоос Криптовалюттай эсэх талаар асуумж авч тэдний хүйсийн хамаарлыг хувиар тооцон Хүснэгт 2-т харууллаа.

Хүснэгт 2. Криптовалюттай эсэх болон хүйсийн хамаарал, %

		Криптовалюттай эсэх		Нийт	Chi-Square
		Байгаа	Байхгүй		
Хүйс	Эрэгтэй	57.1	42.9	100	$\chi^2 = 13.991$ $df=1$ $p=.000$ $n=154$
	Эмэгтэй	27.4	72.6	100	
	Нийт	40.9	59.1	100	

Хүснэгт 2-оос харахад 63 (40.9%) нь криптовалюттай, 91 (59.1%) нь криптовалют байхгүй гэсэн хариулыг өгсөн бөгөөд эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд криптовалюттай байгаа нь харагдаж байгаа нь (4) үнэлгээнээс харагдаж байна.

$$\chi^2(1, N = 154) = 13.991, p = .000 (4)$$

Түүнчлэн Криптовалютад ач холбогдол өгөхгүй байх шалтгааныг харьцуулан График 5-т үзүүлээ.

График 5. Криптовалютад ач холбогдол өгдөггүй шалтгаан




График 5-т үзүүлсэн харьцуулалтаас 76 (32.3%) нь үнийн тогтворгүй байдал, 50 (21.3%) нь аюулгүй байдлын асуудал, 42 (17.9%) нь эрх зүйн зохицуулалтгүй, 49 (20.9%) нь найдвартай биш, үлдсэн 22 (9.4%) нь бусад шалтгаан гэж хариулсан байгааг харж болно.

Мөн цалингийнхаа тодорхой хувийг криптовалют хэлбэрээр авахыг зөвшөөрөх үү гэсэн асуумж ба Криптовалюттай эсэх гэсэн асуумж хооронд харилцан хамаарал байгаа эсэхийг тооцон хувиар илэрхийлэн Хүснэгт 3-р харууллаа.

Хүснэгт 3. Криптовалюттай эсэх болон цалингийнхаа тодорхой хувийг криптовалют хэлбэрээр авахыг зөвшөөрөх эсэх хоорондын хамаарал, %

		Цалингийнхаа тодорхой хувийг криптовалют хэлбэрээр авахыг зөвшөөрөх эсэх			Нийт	Chi-Square
		Зөвшөөрнө	Зөвшөөрөхгүй	Мэдэхгүй		
Криптовалют тай эсэх	Байгаа	58.7	15.9	25.4	100	$\chi^2 = 20.17$ $df=2$ $p=.000$ $n=154$
	Байхгүй	23.1	30.8	46.2	100	
Нийт		37.7	24.7	37.7	100	


Хүснэгт 3-аас харахад цалин, орлогынхоо тодорхой хувийг криптовалют хэлбэрээр авахыг зөвшөөрөх эсэх талаар тодруулахад 58 (37.7%) нь зөвшөөрнө, 38 (24.7%) нь зөвшөөрөхгүй, 58 (37.7%) нь мэдэхгүй гэж хариулсан. Үр дүнгээс харахад криптовалюттай хүмүүс криптовалютгүй хүмүүсээс илүүтэйгээр цалин, орлогынхоо тодорхой хувийг криптовалют хэлбэрээр авахыг зөвшөөрсөн байгаа нь (5) үнэлгээнээс харагдаж байна.

$$\chi^2 (2, N = 154) = 20.17, p = .000 (5).$$

Түүнчлэн, оролцогчдын 102 (67.5%) нь ямар нэгэн аппликейшн ашиглаж койн


цуглуулах оролдлого хийж байсан бол 49 (32.5%) нь хийж байгаагүй байна. Оролцогчдын дийлэнх нь буюу 52 (50%) нь Пикойныг, үлдсэн 52 (50%) нь бусад төрлийн аппликейшнууд болох Ардкойн, Платинкойн, "Onecoin"-ийг ашиглан койн цуглуулах оролдлого хийж байсан гэжээ. Нийт оролцогчдоос цуглуулсан койноо уламжлалт мөнгө болгох аргыг мэдэх эсэх талаар асуухад оролцогчдын 56 (46.2%) нь цуглуулсан койноо хэрхэн уламжлалт мөнгө болгохоо мэдэхгүй гэсэн бол 63 (52.9%) нь энэ талаар мэднэ гэж хариулсныг График 6-аас харж болно.

График 6. Цуглуулсан койноо уламжлалт мөнгө болгох аргыг мэдэх эсэх




Криптовалютыг ямар зорилгоор ашигладгийг мэдэх зорилгоор дээрх асуултыг хэдэн ч хариулт сонгож болохоор судалгаандаа оруулсан ба тус асуултын үр дүнд оролцогчдын дийлэнх буюу 110 (46.3%), 116 (49.4%) нь харилцан хөрөнгө оруулалтын зорилгоор болон арилжаа хийх зорилгоор гэсэн хариултуудыг өгсөн байсныг График 7-оор харууллаа.

График 7. Криптовалютыг ямар зорилгоор ашигладаг




Мөн судалгаанд оролцогчдын 133 (87.5%) нь өөрсдөд нь криптовалютын талаар мэдээлэл хэрэгтэй байна гэсэн бол 19 (12.5%) нь мэдээлэл хэрэггүй гэж хариулсныг харьцуулан График 8-д үзүүлээ.

График 8. Криптовалютын талаарх мэдлэг, мэдээлэл хэрэгцээтэй эсэх



Монгол улсад криптовалютын тухай хууль, эрх зүйн зохицуулалт хэрэгтэй буй эсэхийг тандах зорилгоор судалгаанд оролцогчдоос 1-5 оноогоор (1-ямар ч хэрэггүй, 5-маш их хэрэгтэй) ашиглан үнэлүүлэх маягаар асуулга авснаас нийт оролцогчдын дийлэнх хувь буюу 67 (43.5%) хүн энэ төрлийн хэрэгцээ шаардлага маш их байна гэсэн хариултыг өгснийг График 9-т харууллаа.

График 9. Монголд криптовалютын тухай хууль, эрх зүйн зохицуулалт хэрэгтэй эсэх, хувиар



IV. Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 65.3% нь криптовалютын талаар тодорхой ойлголттой байгаа ба хүйсийн хувьд эрэгтэйчүүд илүү ихээр сонирхож байгаа нь ажиглагдаж байна. Түүнчлэн криптовалютын талаарх мэдээлэл авдаг гол хэрэгсэл нь олон нийтийн сүлжээ гэж үзэж болох юм. Улмаар блокчейн технологийн талаарх мэдлэгээ үнэлэх асуулгад оролцогчдын хамгийн их буюу 35.9% нь “дунд” гэж үнэлсэн нь олон нийт ерөнхий мэдээлэлтэй байгаа ч арилжаанд оролцоход шаардлагатай түвшинд хүрэхгүйг илтгэж байна. Криптовалютыг уламжлалт валюттай харьцуулсан асуулгад оролцогчдын 64.9% нь төв банкинд баталгаа бүхий үндэсний валютуудтай адилтгасан явдал нь хэрэглэгчдийн дунд криптовалютад үзүүлэх итгэл тодорхой хэмжээнд буй болсны илэрхийлэл хэмээн дүгнэж болно. Харин криптовалютын хэрэглээнээс татгалзаж буй шалтгаан нь үнийн тогтворгүй байдлаас үүсэх эрсдэлээс ихээхэн хамаарч байгаа талаар ажиглагдаж байна. Цалинг криптовалютаар олгоход 37.7% нь зөвшөөрнө гэж хариулсан ба мөн ижил хувьтай оролцогчид “мэдэхгүй” гэсэн хариултыг сонгосныг үзэхэд криптовалютын үнэ цэнэд хандах олон нийтийн үзэл санаа ялгаатай бүлгүүдэд хуваагдсан байна.

Гэвч криптовалютыг түгээмэл хэрэглээнд нэвтрүүлэхэд хэрхэн ашиглах талаарх ойлголт олонх хэрэглэгчдэд байхгүй нь криптовалютад эргэлзэх байдлыг үүсгэж байна. Хоёр оролцогч тутмын нэг нь “Пикойнаппликейшн”-ыг ашиглаж үзсэн үр дүнгээс харахад криптовалют хэрэглэгчдийн дунд тус аппликейшн хамгийн их хувийг эзэлж байгаа ч “Ард койн” гэх мэт зарим аппликейшнүүд сүүлийн үед нийтийн хэрэглээнд нэвтрэн өргөнөөр ашиглагдаж байна. Хэрэглэгчид ихэвчлэн харилцан хөрөнгө оруулалт хийх, арилжаа хийх зорилгоор криптовалютыг ашигладаг боловч криптовалютын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах эрэлт нийт судалгаанд оролцогчдын 87.5%-д оршиж байна. Үүнээс үзэхэд олон нийтийн дундах ойлголт харилцан адилгүй, зохих ойлголттой байсан ч тухайн мэдээлэлд эргэлзэх хандлага байгаа нь тодорхой эрсдэлийг дагуулж буй. Мөн уг байдлыг судалгаанд оролцогчдын 43.5% нь Монгол улсад криптовалютад хамаарах эрх зүйн зохицуулалт маш их хэрэгтэй гэсэн хариулт өгснөөс харж болно.

Ийнхүү Монгол Улсад криптовалютыг сонирхох явдал ихсэж байгаатай уялдуулан криптовалютын эрх зүйн статусыг тодорхой болгох нь зүйтэй ба цаашид криптовалютын арилжаанд хяналт тавих, орлогод татвар ногдуулах гэх мэтээр шийдвэрлэх нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд эерэг нөлөөтэй ба криптовалютын ашиглалтыг бусад хууль бус үйл ажиллагаанаас ангид байлгах үр дагавартай байх юм.

Ашигласан материал

АНУ-ын Конгрессын Номын Сан, Дэлхий даяарх криптовалютын эрх зүйн зохицуулалтын судалгаа, 2018, <https://www.loc.gov/collections/publications-of-the-law-library-of-congress/about-this-collection/cryptocurrency-world-survey.pdf>.

АрдАкадеми, Блокчэйн - Интернетийн шинэ хувьсгал, 2021, <https://academy.ard.mn/blog/revolutionising-the-internet>.

Бизнес Инсайдер, Өмнөд Солонгос Криптовалютод 20 хувийн татвар ногдуулна нийтлэл, 2021, <https://markets.businessinsider.com/news/currencies/south-korea-tax-cryptocurrency-transactions-20-percent-bitcoin-capital-2021-5>.

Монгол банк, Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, 2021, <https://bit.ly/38NH4hY>.

СЗХ, Криптовалютын талаарх Санхүүгийн Зохицуулах Хорооны байр суурь, 2017, <http://www.frc.mn/a/2558>.

Хэргийн дугаар C-264/14, Skatteverket v. David Hedqvist, ECLI:EU:C:2015:718, <https://perma.cc/7Q6Q-MM9V>.

Тэмдэглэл

Зохиогчдийн тухай

Б.Батхүү нь Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн ухааны сургуульд “Социологи” хөтөлбөрөөр бакалаврын түвшинд суралцаж, 2021 онд төгссөн.

Б.Улсболд нь МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Олон улсын эрх зүйн ангид эрх зүй чиглэлээр бакалаврын зэрэг дүүргэсэн ба нийт төгсөгчдөө голч оноо болон бусад амжилтаараа тэргүүлж, МУИС-ийн Шилдгийн Шилдэг Төгсөгчөөр шалгарсан.

Г.Наранцэцэг нь Монгол Улсын Их сургуулийн Олон Улсын Харилцаа Нийтийн Удирдлагын сургуулийг Олон Улсын Харилцаа мэргэжлээр 2021 онд төгссөн.

Ч.Авидмаа нь МУИС-н ОУХНУС-г 2021 онд Олон улсын харилцааны мэргэжлээр сурч төгссөн.

Э.Тамир нь МУИС -д олон улсын харилцааны чиглэлээр суралцаж, 2021 онд төгссөн.

Судалгааны чиглэл нь олон улсын эдийн засгийн харилцаа, Монголын гадаад бодлогын түүх, үндэсний аюулгүй байдал.

Импрессум

© Фридрих-Эбертийн Сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газраас эрхлэн гаргав. Улаанбаатар хот, 2021 он

Агуулгын хариуцлага:

Бэнэдикт Ивановс, ФЭС-ийн суурин төлөөлөгч

Утас: +976 11 312-892

Факс: +976 11 312-889

Вэб сайт: mongolia.fes.de QR code

Холбоо барих хаяг: info@fes-mongolia.org

Фэйсбүүк: [@fesmongolia](https://www.facebook.com/fesmongolia)

Энэхүү хэвлэлд нийтлэгдсэн үзэл бодол нь ФЭСгийн үзэл бодолтой заавал нийцэж байх албагүй.

ФЭС-гаас эрхлэн гаргасан хэвлэгдмэл материалыг

ФЭС-гаас бичгээр зөвшөөрөл авалгүйгээр арилжааны зориулалтаар ашиглахыг зөвшөөрөхгүй.

1925 онд байгуулагдсан Фридрих-Эбертийн сан нь Германы хамгийн ууган уламжлалт улс төрийн сан юм. Манай сан Германы эзэнт улсын анхны ардчилсан ерөнхийлөгч Фридрих Эбертийн гэрээслэлийн дагуу байгуулагдаж түүний нэрээр нэрлэгдсэн. Фридрих-Эбертийн сангийн улс төрийн өв, гүйцэтгэж буй үүрэг нь түүний үзэл санаа, гэрээслэлээс эхтэй.

<https://mongolia.fes.de/>

